

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙ: ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Ч.Чойсамба*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, сэтгүүлчдийн мэргэжлийн нийтлэг, зарчим, ганц хүний сэтгүүл зүй, нийгмийн өмнө хэвлэлийн хүлээх хариуцлагын онол, олон улсын сэтгүүлчдийн байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл

Нийгэмд ОНМХ-ийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэхийн хэрээр сэтгүүлчийн ёс зүйн зарчмын ач холбогдол улам бүр өсч байна. Чухамдаа сэтгүүлч л жирийн иргэнээс авахуулаад удирдах албан тушаалтан, сайд дарга, төрийн тэргүүнийг хүртэл ОНМХ-ээр шүүмжлэх эрхтэй байдаг. Гагцхүү сэтгүүлчийг л ОНМХ-ээр шүүмжлэх тийм дархан эрх хэнд ч албан ёсоор заяагдаагүй. Байдал ийм учир алдсан эндсэн нэгнийхээ алдаа дутагдлыг нь засч залруулахад туслах, нэгэнт гаргасан алдаагаа хойшид давтахгүй байх, өөр мэргэжлийнхэнд байдаггүй давуу эрхээ хэтрүүлэн ашиглаж, хэн нэгэнд сэтгэл санааны болон бусад хохирол учруулахгүйн тулд сэтгүүлч сэтгүүлчээ шүүмжилж байхаас өөр арга үгүй юм. Нийгмийг бүхэлд нь эмчилж байдаг, бас цагдаж байдаг нийгмийн эмч, нийгмийн

цагдаагийн үүргийг давхар гүйцэтгэдэг сэтгүүлч өөрөө хэдий чинээ ёс зүйтэй байна, төдий чинээ түүний үг жин татна.

Өнөөдөр манай нийгэмд сэтгүүлч сэтгүүлчээ шүүмжлэх ёсгүй гэсэн бичигдээгүй хууль үйлчилж байна. Энэ бол ёс зүйгүй найзыгаа өмгөөлөхдөө гаргаж ирсэн «хууль». Энэ бол өөрийгөө хаацайлахын тулд ёс зүйгүй сэтгүүлчдийн уухайлан шүүрч авсан «хууль». Ингэснээр ёс зүйгүй нэгнээ шүүмжилсэн, нөхөр ёсны зөвлөгөө өгсөн сэтгүүлч рүү дайрдаг, «барьж иддэг» тогтолцоо бүрдчихээд байгаа нь нууц биш юм. Яг үнэндээ сэтгүүлчийн гаргасан мэргэжлийн алдааг оношилдог арга, хэмждэг хэмжүүр манайд илт дутагдаж байна. Тэгвэл тухайн сэтгүүлч мэргэжлийн алдаа гаргасан эсэхийг оношилдог ганц «багаж» бол сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн зарчим юм.

Сэтгүүлчийн ёс зүйн зарчим бол дарга дээрээс тулгадаг, эсвэл эрдэмтэн өрөөндөө сууж байгаад боловсруулчихдаг шаардлагуудын хэлхээ огтхон ч биш. Сэтгүүлчийн ёс зүйн зарчим бол тогоонд нь чанагдсан сэтгүүлчид өөрсдийн туршлага дээр

тулгуурлан боловсруулж, баталдаг мэргэжлийн үйл ажиллагааны мөрдлөг юм.

Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй чухам хэдийд үүссэн талаар хоёр өөр байр суурь бий. Ёс зүй нь сэтгүүл зүйтэй цуг, өөрөөр хэлбэл, мэдээллийг аман хэлбэрээр тараадаг байсан тэр балар эрт цагт үүссэн гэж нэг хэсэг судлаач үздэг бол нөгөө хэсэг нь сэтгүүл зүй олон нийтийнх болсон тэр цагт, тодруулбал, XIX зууны дунд үед бий болсон гэдэг.

Оросын судлаач И.А. Кумылганова эхний байр суурийг дэмждэг. Тэрээр: «Түүхийн хуудсыг сөхөхөд сэтгүүл зүйг үүссэн цагаас хойш мэргэжлийн ёс зүй түүний салшгүй нэг хэсэг байжээ. Өөрөөр хэлбэл, <...> сэтгүүл зүй хөдөлмөрийн үйл ажиллагааны бие даасан салбар болж ялгаварлахад энэхүү салбарын ажилтны ёс суртахууны ухамсар ч бүрэлдэж, төлөвшиж байв»¹ гэж үздэг.

Харин Д.С. Авраамов энэ асуудлаар өөр үзэл бодолтой. Түүний үзэж буйгаар, мэргэжлийн ёс зүй нь мэргэжлийн нийтлэг буй нөхцөлд л бүрэлдэх боломжтой, тэгвэл сэтгүүлчдийн мэргэжлийн нийтлэг нь 1830–1840-өөд оны үед бий болжээ².

Ямартаа ч сэтгүүлчдийн эрх, үүргийн тухай мэтгэлцээн сэтгүүлчдийн нийтлэг (орчин үеийн утгаар нь) үүсэхээс өмнө эхэлсэн байдаг. Эл мэтгэлцээн XVII зууны эхээр анхны сонинууд хэвлэгдэх болсны дараа дэлгэрчээ. Уг асуудлыг анх хэвлэл эрхлэгчид өөрсдөө сөхөж гаргасан нь сонирхолтой. Францын албан ёсны анхны сонин «La Gazette» («Сонин»)–ын эхний дугаар 1631 оны 5 дугаар сарын 30-нд хэвлэгдэн гарсан

байна. Эрхлэн гаргагч Теофраст Ренодо анхны дугаартаа уншигчиддаа хандаж: «Уншигчдад таалагдахгүй байж магадгүй гэж эмээснээс олон түүхч өөрийн амьдарч буй зууны түүхийг бичдэггүй. Тэгвэл тэр долоо хоногийн, бүр тэр өдрийн түүхийг бичиж, уншигчдад толилуулах нь зохиогчийн хувьд хэчнээн аюултай ажил болохыг төсөөлөөд үзнэ үү. Шинэ зүйл мэдэх гэсэн уншигч таны хүсэл надад маш богино хугацаа олгосныг болгооно уу. Хүлээж авсан материалтайгаа танилцаад, хэвлэх хүртэл ердөө дөрөвхөн цагийн зай надад байдаг бөгөөд уншигчдын гар дээр очих энэ бүтээлийн талаар хамгийн ширүүн шүүмжлэгчдэд ч өршөөлийн үг олдоно гэдэгт би эргэлзэхгүй»³ гэж бичсэн байдаг.

Хойд Америкийн сэтгүүл зүйн үндсийг тавьсан «Publick Occurrences, Both Forreign and Domestick» («Гадаадын болон орон нутгийн нийгмийн үйл явдлууд», тухайн үеийн бичлэгийг хэвээр үлдээв) сонинг үүсгэн байгуулагч Бенжамин Харрис үйл явдлын тухай мэдээлэхдээ бодит үнэнийг эрхэмлэж, эх сурвалжуудад хянуур хандаж, алдаа мадаг гаргавал залруулахаа 1690 оны 9 дүгээр сарын 25-нд хэвлэгдсэн анхны бөгөөд эцсийн дугаартаа амлажээ. Тус сонинд нийтлэгдсэн зарим мэдээлэл «эргэлзээтэй бөгөөд найдваргүй» гэж Массачусетс мужийн амбан захирагч үзсэн учир тус сонинг хаасан байна⁴.

Оросын суут эрдэмтэн Михаил Васильевич Ломоносов 1755 онд «Философийн эрх чөлөөг тэтгэх зорилготой нийтлэл бичихэд сэтгүүлчдийн баримтлах ёстой үүргийн тухай

эргэцүүлэл» өгүүллээ Амстердамын «Герман судлалын шинэ номын сан буюу Герман, Швейцарь, Умардын орнуудын уран зохиолын түүх» сэтгүүлд франц хэлээр нийтлүүлсэн байна. Тэрбээр сэтгүүлчийн хөдөлмөрийг үнэнд үйлчлэхэд зориулагдсан бүтээлч ажил гэж тодорхойлоод, энэ мэргэжлийг сонгосон хүнд «Мэдлэг хийгээд сэтгэлийн тэнхээ... хэрэгтэй. Өдөр тутам тулгарч байдаг олон төрлийн асуудлыг үндэслэлтэй, даацтай дэлгэн тавихын тулд мэдлэг, гадны болон дотоод нөлөөнд авталгүй зөвхөн үнэнийг хэлбэрэлтгүй баримтлахын тулд сэтгэлийн тэнхээ чухал» гэж тэмдэглэсэн нь бий. Түүнчлэн «мэдлэгтэй, гярай, шударга, даруухан» сэтгүүлч л мэргэжлийн ажлаа амжилттай гүйцэтгэж чадна гэсэн байдаг⁵. Хэдийгээр энэ өгүүлэл практик сэтгүүл зүйн гэхээсээ илүүтэй шинжлэх ухааны сэтгүүл зүйн бүтээл боловч зарим судлаач үүнийг сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн анхны зарчим байсан гэх үзэх нь бий. Гэхдээ хэрэв асуудалд Д.С. Авраамовын байр сууринаас хандвал гагцхүү мэргэжлийн нийтлэг дэмжиж байж л мэргэжлийн ёс зүйн зарчмын тухай ярьж болно. Тэгвэл Оросод мэргэжлийн нийтлэг XVIII зуунд байгаагүй. Тиймээс М.Ломоносов тус өгүүллээрээ сэтгүүл зүйд мэргэжлийн ёс зүй чухал гэсэн санааг дэвшүүлсэн гэж үзэх нь үнэнд илүүтэй ойртоно.

1609 оны 1 дүгээр сард Германы Страсбург хотноо хүн төрөлхтний анхны сонин хэвлэгдэн гарснаас хойш бараг хоёр зууны турш дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ганц хүний сэтгүүл зүй гэгч ноёрхсон байна. Энэ нь ганц хүн мэдээллээ олоод,

түүнийгээ боловсруулаад, дараа нь редакторлаад, энэ бүхний эцэст үсгээ өрөөд, хэвлээд, өөрөө түгээдэг байсан гэсэн үг⁶. Ганц хүний сэтгүүл зүй ноёрхож байсан тэр үед мэргэжлийн ёс зүйн тухай өгүүлэх хэт эртдэх юм. Учир нь сэтгүүлч гэдэг мэргэжил ч байсангүй, сэтгүүлчийн хөдөлмөрийн хуваарилалт ч байсангүй.

Одоогоос зуу гаруй жилийн тэртээ дэлхийн тэргүүний орнуудад боловсролтой хүмүүсийн тоо нэмэгдэж, тэдний ухамсар дээшлэхийн хэрээр өөрсдийг нь сэтгүүлчид эрээ цээргүй, хүссэнээрээ мунхруулж байгаад олон түмэн зүй ёсоор бухимдаж эхэлсэн байна. Гэхдээ энэхүү бухимдал гэнэт, ганц нэг нийтлэлийг дагаад бий болчихсонгүй.

Олон түмэнд буюу массд хандсан хэвлэл 1830-аад оны үед АНУ-д үүсэхдээ анхнаасаа л шуугиан сенсаци, гэмт хэргийн тухай энгийн хэллэгээр бичигдсэн нийтлэлүүдийг амтархан уншдаг бүдүүлэгдүү аудиторийг бай болгожээ. Ийм хэвлэлийн «загалмайлсан эцэг» нь Бенжамин Дэй юм. 1833 оны 9 дүгээр сарын 3-нд Нью-Йоркт «Нар бүгдийг гэрэлтүүлдэг» уриатай «The Sun» («Нар») сонины анхны дугаар уншигчдын гар дээр очсон байна. Шуугиан сенсаци, гэмт хэрэгт түлхүү анхаардаг Дэй сонирхолтой материал олдохгүй болохоор санаанаасаа зохиочих нь энгийн үзэгдэл болов. «The Sun»-ы 1835 оны 8 дугаар сарын 25-ны дугаарт нийтлэгдсэн одон орон судлаач Жон Гершель Өмнөд Африкийн Таатай найдварын хошуун дээр байрлуулсан, бичил биетийг 42000 дахин томсгодог асар хүчтэй

телескопын тусламжтайгаар Саран дээр амьдардаг жижигхэн хүмүүсийг илрүүлсэн тухай мэдээлэл олныг шуугиулжээ. Энэхүү мэдээллийг Английн «The Edinburgh Journal» («Эдинбургийн сэтгүүл»)–ын хавсралтаас авснаа сонин дурдсан байна. Дараагийн дугаарт Саран дээр амьдардаг хүмүүсийг: «Өндрөөрөө 122 см орчим, нүүрнээсээ бусад биеийн хэсгээр шаравтар үсэн бүрхүүлтэй, багваахай шиг сарьсан далавчтай» гэж дүрсэлжээ. «The Sun»-ы борлогдох хувь хэдхэн өдрийн дотор хэд дахин нэмэгдэв. Уншигчид редакцийн газрыг захидлаар булж, «саран»-чуудын ахуй амьдралын тухай үргэлжлүүлэн нийтлэх, болж өгвөл тэднийг дүрсэлсэн зураг гаргахыг нэгэн дуугаар шаардаж байлаа. «Тэднийг дуран авайгаар харж байхад хоорондоо юм ярьж байсан нь илэрхий» гэх зэрэг мэдээлэл гэнэн уншигчдыг итгүүлж чаджээ. Удалгүй Англиас «The Edinburgh Journal»-д ямар ч хавсралт байхгүй, «The Sun»-ы нийтлэл бодит үнэнд нийцэхгүй болохыг хариуцлагатайгаар мэдэгдсэнээр Сарны үлгэр дуусгавар болжээ. Гэвч тус сонин нэгэнт өөрийн хүрээний уншигчидтай болсон байв.

«The Sun»-ы араас нийтлэлийн бодлогын хувьд анхдагчаа өвчсөн мэт дуурайсан хэвлэлүүд шил шилээ даган үүсчээ. XIX зууны хоёрдугаар хагас бол олон түмний хэвлэлийн цэцэглэлтийн

үе байлаа. Ийм хэвлэл Англи, Франц зэрэг оронд үүсч, асар богино хугацаанд олон түмний итгэлийг «байлдан дагуулж» байв.

XIX зууны сүүл – XX зууны эхээр мэдээллийг ухуулга сурталчилгаа, «тархи угаах» атгаг зорилгоор ашигладаг хэвлэлийн хүчирхэг монополиуд Баруун Европ, Хойд Америкт үүсчээ. Үүний сацуу нийгэмд, юуны түрүүнд бизнесийн бүлэглэл, улс

төрчдийн гарт тоглоом болохыг хүсээгүй сэтгүүлчдийн өөрсдийнх нь дунд түгшүүр бий болгосон байна. Үүнд өөр нэг хүчин зүйл нөлөөлсөн нь олон нийтийн бухимдал дээр дөрөөлж хэвлэлийн эрх чөлөөг боомилсон хууль тогтоомж гаргах замаар төрийн зүгээс зохицуулах явдал байв. Ийм нөхцөлд

XX зууны эхээр ОНМХ-ийн ёс зүйн өөрийн зохицуулалтын асуудал хөндөгджээ⁷.

Өөрийн зохицуулалтын гурван үндсэн механизм байдаг нь ёс зүйн зарчим, хэвлэлийн зөвлөл, хэвлэлийн омбудсмен юм. Эдгээрээс ёс зүйн зарчмын тухай тогтож ярья.

Нэгдүгээр давалгаа. Ёс зүйн зарчим боловсруулах анхны оролдлогууд XIX зууны сүүлээр хийгдэж эхэлжээ. 1890 онд АНУ-д, 1896 онд Галисид сэтгүүлчдийн зан байдлын хэм хэмжээг зохицуулсан журмууд боловсруулагд-

«

Ёс зүйн зарчим боловсруулах анхны оролдлогууд XIX зууны сүүлээр хийгдэж эхэлжээ. 1890 онд АНУ-д, 1896 онд Галисид сэтгүүлчдийн зан байдлын хэм хэмжээг зохицуулсан журмууд боловсруулагдсан боловч өргөн түгээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй учир заавал дагаж мөрдөх зарчимд тооцогддоггүй

»

сан боловч өргөн түгээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй учир заавал дагаж мөрдөх зарчимд тооцогддоггүй⁸.

XX зууны эхээр дэлхийн тэргүүний орнуудад, тухайлбал, Герман, АНУ-д сэтгүүлч бэлтгэн гаргадаг сургуулиуд үүссэн явдал ёс зүйн зарчмын цаашдын хөгжилд зохих нөлөө үзүүлжээ. 1900 оны орчим Шведэд сэтгүүлчдэд зориулсан ёс зүйн зарчмыг баталсан ч тухайн үед Скандинавын энэ оронд сэтгүүлчдийн мэргэжлийн холбоо байгаагүй учир үүнийг сэтгүүлчид нь тэр бүр мөрдлөг болгодоггүй байжээ.

1910 онд Канзас муж улсын Редакторуудын нийгэмлэг байгууллагынхаа ёс зүйн зарчмыг баталсан нь АНУ-д анхных байв. Тэгвэл Францад Сэтгүүлчдийн үндэсний синдикатаар 1918 онд баталсан «Зан байдлын харти»-г сэтгүүлчдийн ёс зүйн анхны зарчим гэж үздэг.

Энэ үеэс эхлэн олон улсын сэтгүүлчдийн уулзалт-хурлууд зохиогдох болжээ. 1921 онд Гонолууд болсон эдгээр уулзалт-хурлын нэгнийнх нь үеэр Америкийн сэтгүүлч Жеймс Браун сэтгүүлчдэд зориулсан зан байдлын олон улсын зарчим батлахыг санал болгосон юм. Гэвч түүний зохиосон «Сэтгүүлчийн практикийн ёс зүй хийгээд хэм хэмжээний кодекс»-ыг хурлаар батлаагүй байна.

Хэдийгээр Брауны санал дэмжлэг аваагүй ч уулзалт-хурлын нөлөөн дор Швед, Бразил, Финлянд зэрэг улсад сэтгүүлчид өөр өөрсдийн ёс зүйн зарчмыг боловсруулж, баталж, мөрдөж эхэлсэн нь том амжилт байлаа. 1923 онд «Сэтгүүл зүйн канонууд» нэртэй ёс

зүйн зарчмыг АНУ-д баталсан байна. Энэхүү зарчмыг баталсан Америкийн сонины редакторуудын нийгэмлэг (American Society of News Editors) өдгөө ч үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сэтгүүлчийн ёс зүйн асуудлуудыг тусгадаг товхимлыг сар тутам хэвлэдэг ажээ.

1926 онд Америк дундын хэвлэлийн нийгэмлэг (InterAmerican Press Association) сэтгүүлчийн ёс зүйн зарчим баталсан нь олон улсын сэтгүүлчдийн ёс зүйн анхны зарчимд тооцогддог. НҮБ байгуулагдахаас өмнө үйл ажиллагаа явуулж байгаад сайн дураараа тарсан Үндэстнүүдийн лиг 1936 онд Женевт «Өргөн нэвтрүүлгийг энхийн зорилгоор ашиглах тухай олон улсын конвенци»-г баталжээ⁹. Өдгөө сэтгүүлчдийн үндэстэн дамнасан хамгийн том байгууллагын нэг болох Олон улсын сэтгүүлчдийн холбоо (International Federation of Journalists) 1939 онд өөрийн ёс зүйн зарчмыг баталсан байна¹⁰.

Сэтгүүлчийн ёс зүйн анхны зарчмуудыг үзэхэд тэдгээрийг зохиогчид нь чөлөөт хэвлэлийн буюу либерталь концепцийг баримтлагчид байсан нь илэрхий. Тус концепци XVII – XVIII зууны сэтгэгчид Жон Мильтон, Томас Жефферсон, Жон Стюарт Миллийн үзэл бодлоос гол санаагаа шавхсан байдаг. Либерталь концепцийн үндсэн санааг базвал:

1-рт, хэвлэл бол нийгмийн институт мөн бөгөөд мэдээлэх, олон түмнийг зугаацуулах, төр засгийг хянахад ард түмэнд тусалдаг гол хэрэгсэл юм. Товчоор хэлбэл, хэвлэл бол ардчиллын хоточ нохой мөн.

2-рт, хэвлэл бол иргэн бүрт нээлттэй бөгөөд бололцоотой хүн бүхэн сонин гаргах эрхтэй.

3-рт, гүжир гүтгэлэг, ёс зүйгүй авир хэвлэлд харш.

4-рт, хэвлэл бол дөрөв дэх засаглал. Хэвлэл нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ.

Эдгээр санаан дээр тулгуурлан зохиогдсон ёс зүйн анхны зарчмуудад хэвлэлийн эрх чөлөө, үнэн бодит мэдээлэл авах ард түмний эрхийг тунхагласан байдаг. Сэтгүүлчийн ёс зүйн анхны зарчмуудын гол санааг тоймловол: үнэнийг бич, баримтанд тулгуурла, хүний нэр төр, хувийн амьдралыг хүндэтгэ, авлига бүү ав, гаргасан алдаагаа залруул, мэдээллийг цуглуулах, түгээхдээ шударга бай, ардчилсан ёсыг хүндэтгэ, хүний ёс суртахууны түгээмэл хэм хэмжээг бүү зөрч гэсэн шаардлага тавьж байв. Ёс зүйн анхны зарчмуудын гол дутагдал бол сэтгүүлчийн мэргэжлийн онцлогийг сайн тусгаж чадаагүй байсан явдал юм.

Либерталь онол дээр тулгуурлан ХХ зуунд «нийгмийн өмнө хэвлэлийн хүлээх хариуцлагын онол» бий болжээ. Энэхүү онолын гавьяа нь нэг талаас хэвлэлийн эрх чөлөө, нөгөө талаас түүнийг хэтрүүлэн ашиглахын хооронд тодорхой зааг тогтоосон явдал юм. Нийгмийн өмнө хэвлэлийн хүлээх хариуцлагын онолыг орчин үеийнх нь хэлбэрээр ХХ зууны 40-өөд оны сүүлээр АНУ-ын судлаач У.Э.Хокинг боловсруулжээ. Өдгөө түүний боловсруулсан онолын суурь санаануудыг дэлхийн олон орны сэтгүүлчдийн байгууллага ёс зүйн зарчимдаа тусгасан байдаг¹¹.

Хоёрдугаар давалгаа. Дэлхийн хоёрдугаар дайн сэтгүүлчийн ёс зүйн зарчмын хөгжилд чөдөр тушаа болжээ. Дайн дуусгавар болсноор энэ асуудал дахин хурцаар тавигдсан бөгөөд 1946 онд ЗХУ-ын манлайлал доор Олон улсын сэтгүүлчдийн байгууллага (International Organization of Journalists)-ын тулгын чулуу тавигдсаны нэг зорилго нь мэргэжлийн ёс зүйн зарчим байв. НҮБ байгуулагдсаныхаа дараахан олон улсын сэтгүүлчийн ёс зүйн зарчмын төсөл боловсруулж, 1950 онд сэтгүүлчдийн 500 байгууллагад тараажээ. Гэвч энэхүү зарчмаар далайлган НҮБ-ын гишүүн орнууд (тухайн үед 58 улс байв) хэвлэлийг залуурдана гэж эмээсэн сэтгүүлчид түүнийг хүлээж авахаас татгалзсан байдаг¹².

Энэхүү төслийн үндсэн дээр 1954 онд Бордод чуулсан Олон улсын сэтгүүлчдийн холбоо хоёрдугаар их хурлаараа «Сэтгүүлчийн зан байдлын зарчмуудын тунхаг»-ийг баталжээ¹³.

Хоёр системийн зөрчил хурцдаж буй нөхцөлд олон улсын зөвшилцөлд хүрэх нь улам бүр хүндрэлтэй болж байсан бөгөөд янз бүрийн түвшний их хурлуудаас баталсан тогтоол, шийдвэрүүдийг царцаасан байна.

Гуравдугаар давалгаа. Вьетнамын дайныг эсэргүүцсэн хөдөлгөөн дэлхийн олон оронд газар авсны дараа 1970-аад эхээр сэтгүүлчийн ёс зүйн асуудал дахин олны анхаарлын төвд оржээ. 1971 онд Европын зургаан орны сэтгүүлчдийн байгууллагын төлөөлөгчид Мюнхений тунхгийг баталсан байна. Уг тунхаг шүүмжлэл өрнүүлэх сэтгүүлчдийн эрхийг бататгаж, сэтгүүлч болон ухуулан сурталчлагчийн мэргэжлийг зааглаж, мэдээлэл олж авахдаа

шударга бус арга хэрэглэхгүй байхыг уриалжээ¹⁴.

1973 онд ЮНЕСКО «Сэтгүүлчид, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ёс зүйн зарчим» сэдвээр олон улсын уулзалт зохион байгуулж, таван жилийн дараа «Энх тайван, олон улсын харилцан ойлголцлыг бэхжүүлэх, хүний эрхийг хөгжүүлэх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, апартеид бодлого, дайн өдөөн хатгахтай тэмцэхэд ОНМХ-ийн оруулж буй хувь нэмэртэй холбоотой үндсэн зарчмуудын тунхаг»-ийг баталсан байна. Дараагийн жилүүдэд ЮНЕСКО-гийн ивээл доор хэд хэдэн уулзалт-хурал зохион байгуулагдсан бөгөөд Олон улсын сэтгүүлчдийн байгууллага (JOI), Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ), Олон улсын хэвлэлийн католик холбоо (UCIP) зэрэг нэр хүнд бүхий байгууллага оролцсон юм.

Прага, Парис хотод 1983 онд зохиогдсон Сэтгүүлчдийн олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын Дөрөвдүгээр зөвлөлдөх уулзантан дээр «Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн олон улсын зарчим» батлагджээ. Энэхүү тунхгийн арван зарчмыг жагсаавал:

Зарчим 1. Үнэн бодит мэдээлэл авах иргэдийн эрх.

Зарчим 2. Үйл явдлыг бодитой тусгах нь сэтгүүлчийн үүрэг мөн.

Зарчим 3. Нийгмийн өмнө хүлээх сэтгүүлчийн хариуцлага.

Зарчим 4. Сэтгүүлчийн мэргэжлийн шударга байдал.

Зарчим 5. Мэдээлэл олж авах болон ОНМХ-ийн үйл ажиллагаанд нэвтрэх олон нийтийн эрх.

Зарчим 6. Хувийн амьдрал, нэр хүндийг хүндэтгэх.

Зарчим 7. Нийгмийн ашиг сонирхлыг хүндэтгэх.

Зарчим 8. Түгээмэл үнэт зүйл, соёлын олонлогт хүндэтгэлтэй хандах.

Зарчим 9. Хүн төрөлхтөнд заналхийлж буй дайн болон бусад гамшгийн эсрэг тэмцэх.

Зарчим 10. Дэлхийн мэдээллийн ба олон нийтийн харилцааны шинэ дэг журмыг хөгжүүлэх¹⁵ юм.

Дөрөвдүгээр давалгаа. 1990-ээд оны эхээр дэлхийн улс төрийн тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд гарснаар сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн асуудлыг шинэ түвшинд гарган тавьжээ. Үүнд Персийн булан дахь дайн, ЗХУ-ын болон социалист системийн задрал, дэлхийн газрын зураг дээр шинэ, ардчилсан улсууд олноор бий болсон явдал нөлөөлсөн байдаг. Хөгжлийн ардчилсан замыг сонгосон Дорнод Европын болон Азийн орнууд үндэсний сэтгүүлчийн ёс зүйн зарчмуудыг баталж эхэлсэн нь энэ үеийн нэг онцлог байв.

Манай оронд өөрчлөн байгуулалтын салхи сэвэлзсэн 1980-аад оны дунд үеэс сэтгүүлчийн ёс зүйн тухай нэлээд хүчтэй ярьж эхэлсэн бөгөөд 1988 онд МСХ-ны дэргэд «Үнэн» сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга Б.Ганбатаар ахлуулсан «Сэтгүүлчдийн эрх, ёс зүйн зөвлөл»-ийг хэвлэл мэдээллийн янз бүрийн байгууллагыг төлөөлсөн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Энэ зөвлөл тухайн үед мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаж, хариуцлага алдсан сэтгүүлчдийн асуудлыг хэлэлцэж, шийдвэр, зөвлөмж гаргаж байсан нь сэтгүүлчдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх, алдаа

гаргахаас урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлж байв.

МСХ-ны 1989 оны II бүгд хурлаар «Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим» хэмээх Монголын сэтгүүл зүйн түүхэн дэх анхны деонтологийн баримт бичгийг хэлэлцэж баталсан нь сэтгүүлчийн ёс зүйн тулгамдсан асуудлуудыг зохицуулах талаар хийсэн нааштай алхмуудын нэг байлаа. Энэ баримт бичиг тухайн цаг үеийн шинж тэмдгийн илрэл болсон ч үнэн бодитой баримт, мэдээлэл, чигч шударгыг эрхэмлэх, ач холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулахыг цээрлэх, үйл явдал, баримтыг гуйвуулахгүй байх, санаанаасаа зохиох, сэтгэлдээ нийцээгүй хүнийг мөрдөн мөшгих, хувийн тооцоо хийх, шан харамж авах, бие хүний нэр төрийг гутаан доромжлох, иргэдийн хувийн халдашгүй нууцыг задруулахгүй байх, хүний эрх, нэр төрийг хүндэтгэх¹⁶ зэрэг сэтгүүлчдийн баримтлах ёстой мэргэжлийн зарчмуудыг өргөн хүрээнд тодорхойлж өгснөөрөө чухал ач холбогдолтой болсон юм.

Сэтгүүлчдийн ёс зүйн зарчим, хэм хэмжээг зөрчсөн Монголын сэтгүүлчдийн холбооны гишүүнд дутагдлыг нөхөрсгөөр хэлж өгөх, сануулах, донгодох, хатуу донгодох, сэтгүүлчийн мэргэжлээр ажиллахаас тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, МСХ-ны гишүүнээс хөөх зэрэг арга хэмжээ авч, шийтгэл хүлээлгэх бөгөөд энэ асуудлыг сэтгүүлчдийн анхан шатны байгууллагын хурлаар, давж заалдсан гомдлыг МСХ-ны хорооны дэргэдэх Сэтгүүлчдийн эрх, ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэхээр заажээ. Харамсалтай

нь ардчилсан хувьсгалын үед энэ практик мартагдсан ажээ.

Монголд Сэтгүүлчдийн эрх, ёс зүйн зөвлөл байгуулагдаж, «Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим» батлагдсан нь дэвшилтэт үйл явдал байв. ЗХУ-д Сэтгүүлчдийн холбооны дэргэд Мэргэжлийн ёс зүй, эрх зүйн зөвлөл 1988 онд байгуулагдаж, 1989 оны 12 дугаар сард «Зөвлөлтийн сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн зарчим» батлагдсаныг энд дурдах нь зүйтэй¹⁷.

1990-ээд оны эхээр чөлөөт хэвлэл оршин тогтнохыг төрөөс хүлээн зөвшөөрч, ХМХ-д тавих цензурыг халсан нь дэвшилтэт үйл явдал болсон ч багагүй хар сүүдэр дагуулсны нэг нь сэтгүүлчдийн ёс зүйн ялзрал байв. Цаг үеийн шаардлагаар 1996 онд МСХ, МЧАСЭ хамтарч «Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим»-ыг боловсруулан баталжээ. Энэ нь Брюссельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн холбооны «Сэтгүүлчдийн баримтлах зарчмуудын тунхаг»-т «Үндэснийхээ уламжлал, ёс заншлыг уран бүтээлдээ ёсчлон дагана» гэсэн өгүүлбэрийг нэмсэн ёс зүйн код байсан юм.

Харин 2003 онд Монголын чөлөөт сонинуудын холбооны бага хурлаар хэлэлцэж, тунхагласан «Сэтгүүлчийн ёс зүйн зарчим» нь олон улсын болон Монголын сэтгүүлчдийн байгууллагуудаас урьд өмнө гаргаж байсан мэргэжлийн ёс зүйн зарчмуудын үндсэн үзэл баримтлал, утга санааг харгалзан манай орны нийгмийн болон сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн

боловсруулахыг оролдсон шинэлэг баримт бичиг болжээ.

Монголын сэтгүүлчдийн холбоо, Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэл нэгдсэний үндсэн дээр 2002 онд байгуулагдсан МСНЭ 2005 оны 3 дугаар сарын 11-нд хуралдсан II их хурлаасаа «Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим»-ыг баталсан нь сэтгүүлч мэргэжлээр суралцаж буй оюутнууд төгсөхдөө өргөдөг тангараг болоод байна. Энэхүү зарчим 2011 оны 12 дугаар сарын 10-ны Монголын сэтгүүлчдийн XV дугаар их хурлаас шинэчлэн баталсан байдаг.

Ишлэл

¹ *Кумылганова И.А.* 1992. Нравственные критерии в профессиональной журналистской деятельности: Автореф. канд. дисс. М., с. 10. Цит. по: *Лазутина Г.В.* 1999. Профессиональная этика журналиста. М., с. 65.

² См.: *Авраамов Д.С.* 2003. Профессиональная этика журналиста. М., с. 42.

³ *Саломон Л.* 1909. Всеобщая история прессы. СПб., с. 94-95.

⁴ См.: *Sloan W. D., Mullikin Parcell L.* eds. 2002. American Journalism: History, Principles, Practices. Jefferson, NC, p. 44.

⁵ *Ломоносов М.В.* 1952. Полн. собр. соч. Т. 3. М.–Л., с. 230-232.

⁶ *Schudson M.* 1978. Discovering the News. Basic Books, p. 16.

⁷ См.: *Авраамов Д.С.* Указ. соч., с. 54–55.

⁸ *Назаретян К.А.* 2010. Журналистская этика: тенденции развития // Этическая мысль. Российская Академия Наук. Институт философии. Выпуск 10. М., с. 216.

⁹ *Pattyn B.* ed. 2000. Media Ethics: Opening Social Dialogue. Leuven, p. 263.

¹⁰ См.: *Bertrand C.J.* 2007. Media Ethics & Accountability Systems. New Brunswick (NJ)–L., p. 44.

¹¹ См.: *Авраамов Д.С.* Указ. соч., с. 55–57.

¹² *Bertrand C.J.* Op. cit., p. 44.

¹³ http://ethicnet.uta.fi/international/declaration_of_principles_on_the_conduct_of_journalists

¹⁴ *Bertrand C.J.* Op. cit., p. 79–81.

¹⁵ <http://www.mmc2000.net/docs/leggi/UNESCO.pdf>

¹⁶ Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим // «Үнэн», 1989.02.28.

¹⁷ *Ворошилов В.В.* Журналистика. 3-е изд. СПб., 2001, с. 208.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Bertrand C.J.* 2007. Media Ethics & Accountability Systems. New Brunswick (NJ)–L.

2. *Pattyn B.* ed. 2000. Media Ethics: Opening Social Dialogue. Leuven.

3. *Schudson M.* 1978. Discovering the News. Basic Books.

4. *Sloan W. D., Mullikin Parcell L.* eds. 2002. American Journalism: History, Principles, Practices. Jefferson, NC.

5. *Авраамов Д.С.* 2003. Профессиональная этика журналиста. М.

6. *Ворошилов В.В.* Журналистика. 3-е изд. СПб., 2001.

7. *Кумылганова И.А.* 1992. Нравственные критерии в профессиональной журналистской деятельности: Автореф. канд. дисс. М.

8. *Лазутина Г.В.* 1999. Профессиональная этика журналиста. М.

9. *Ломоносов М.В.* 1952. Полн. собр. соч. Т. 3. М.–Л.

10. *Назаретян К.А.* 2010. Журналистская этика: тенденции развития // Этическая мысль. Российская Академия Наук. Институт философии. Выпуск 10. М.

11. *Саломон Л.* 1909. Всеобщая история прессы. СПб.

12. Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим // «Үнэн», 1989.02.28.

13. *Зулькафиль М., Чойсамба Ч.* 2004. Сэтгүүлчийн ёс зүй. УБ.

14. http://ethicnet.uta.fi/international/declaration_of_principles_on_the_conduct_of_journalists

15. <http://www.mmc2000.net/docs/leggi/UNESCO.pdf>